



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/203

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2025 оны А/31 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2025 онд аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгагдсан “Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн засвар, тохижилт”-ын төсөл арга хэмжээний 10,000,000 (арван сая) төгрөгийн зардлаас “Боди ландшафт” ХХК-аас ухаалаг дэлгэц худалдан авахад 5,940,000 (таван сая есөн зуун дөчин мянган) төгрөгөөр, “БСБ Мебель” ХХК-аас 2 ширхэг бичгийн шүүгээ худалдан авахад 3,313,800 (гурван сая гурван зуун арван гурван мянга найман зуун) төгрөгөөр, “Өвөлжөөн булаг” ХХК-аар засвар хийлгэхэд 740,000 (долоон зуун дөчин мянган) төгрөгөөр гэрээ шууд байгуулах эрхийг Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга (Б.Ариунболд)-т олгосугай.

2. Гэрээнд заагдсан засвар, тохижилтын ажлыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Боди ландшафт” ХХК (Ж.Эрдэнэчандмань), “БСБ Мебель” ХХК (Ж.Болорцэцэг), “Өвөлжөөн булаг” ХХК (Б.Өлзийбаяр)-д тус тус үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн засвар, тохижилтын ажлын санхүүжилтийг батлагдсан хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

